

Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2018 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ...
дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

ЗООНОЗ ӨВЧНӨӨС НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ХАМТАРСАН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАЖ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Зооноз өвчнөөс нийгмийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан зөвлөл” (цаашид "хамтарсан зөвлөл" гэх)-ийн зохион байгуулалт, үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна. Хамтарсан зөвлөл нь орон тооны бус байна.

1.2. Хамтарсан зөвлөл нь үйл ажиллагаандаа зооноз өвчнөөс нийгмийн эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, мал, амьтны эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн талаархи үндэсний хөтөлбөрүүдийг удирдлага болгон нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалт, зооноз, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний хүн, мал эмнэлэг бусад салбар хоорондын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж улсын хэмжээнд хариуцна.

1.3. Хамтарсан зөвлөл нь зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.4. Хамтарсан зөвлөл нь орон нутагт салбартай байх ба тухайн аймгийн Засаг даргын тушаалаар баталгаажуулсан байна.

1.5. Хамтарсан зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

Хоёр. Хамтарсан зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Хамтарсан зөвлөлийн дарга нь Эрүүл мэндийн дэд сайд, орлогч дарга нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, нарийн бичгийн дарга нь Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байна. Зөвлөлийн даргыг эзгүйд түүний үүргийг орлогч дарга гүйцэтгэнэ. Техникийн ажлын хэсгийн Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал байна.

2.2. Хамтарсан зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь зөвлөлийн гишүүдийн хурал байна. Зөвлөл нь хагас жил тутмын сүүлийн сард хуралдаж, зоонозын халдварт өвчний бодлогын баримт бичгийн хэрэгжилт, явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэх бөгөөд шаардлагатай үед зөвлөлийн дарга ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

2.3. Хамтарсан зөвлөлийн хурлын шийдвэр нь тэмдэглэл хэлбэртэй байх ба зөвлөлийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурсанаар баталгаажина.

2.4. Хамтарсан зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь ирснээр хурал хүчинтэйд тооцогдох ба хуралд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцож чадахгүй гишүүн саналаа заавал бичгээр хүргүүлнэ.

2.5. Хамтарсан зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга болон техникийн ажлын хэсгийн гишүүд хамтран хангах ба хэлэлцэх асуудлын танилцуулга, шаардлагатай бусад материалыг хурал эхлэхээс 7 хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд танилцуулсан байна. Хэлэлцэх асуудлаар ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

2.6. Хамтарсан зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлаар дүгнэлт, санал бэлтгэх үүрэг бүхий шинжээч томилох, ажлын хэсэг байгуулах асуудлыг зөвлөлийн даргын шийдвэрээр хэрэгжүүлнэ.

2.7. Хурлаар хэлэлцүүлэх асуудлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч эцэслэн хянаж, хэлэлцүүлэх саналыг зөвлөлийн даргад танилцуулж зөвшөөрөл авна.

2.8. Хамтарсан зөвлөлийн хуралд Эрүүл мэнд, Үйлдвэр хөдөө аж ахуйн сайд, холбогдох яам, агентлагийн удирдлагууд оролцож болно.

2.9. Хамтарсан зөвлөл нь жилийн ажлын үр дүнгээ дараа оны 1 дүгээр сард багтаан Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд танилцуулна.

2.10. Хамтарсан зөвлөлийн болон техникийн ажлын хэсгийн гишүүдэд ажлын үр дүнд тулгуурлаж урамшуулал олгож болно.

Гурав. Хамтарсан зөвлөлийн үйл ажиллагааны хамрах хүрээ

Хамтарсан зөвлөл нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

3.1. “Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах” үзэл баримтлалын хүрээнд салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх;

3.2. Салбар хооронд мэдээ, мэдээлэл солилцох;

3.3. Зооноз, шинэ болон сэргэж буй халдварт өвчний үед хамтарсан хариу арга хэмжээг зохион байгуулах бэлэн байдлыг хангах;

3.4. Эрсдэлийн үнэлгээ хийх;

3.5. Хамтарсан судалгаа, шинжилгээ хийх чиглэлийг тодорхойлох, үр дүнд санал, дүгнэлт өгөх;

Дөрөв. Хамтарсан зөвлөлийн даргын үүрэг, эрх

4.1. Зооноз, шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар салбарууд хамтран гүйцэтгэх үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох;

4.2. Бүх түвшинд салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

4.3. Зооноз, шинэ болон сэргэж буй халдварт өвчний дэгдэлтийн үед хамтарсан баг томилж, эрсдлийн үнэлгээ хийх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх;

4.4. Зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний заавар, удирдамж, гарын авлагад нэмэлт оруулахад санал өгөх;

4.5. Үндэсний болон орон нутгийн түвшинд мэргэжлийн байгууллагуудын чадавхийг сайжруулах чиглэлээр санал дэвшүүлэх;

4.6. Хамтарсан зөвлөл нь “Монголын талбарын тархвар судлал” сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

4.7. Батлагдсан төсөвт багтаан зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, техникийн ажлын хэсгийн чиг үүргийг батлах;

4.8. Хамтарсан зөвлөлийн төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;

4.9. Хамтарсан зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээлэл гаргуулах;

4.10. Зоонозын халдварт өвчний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулах талаар Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах.

Тав. Хамтарсан зөвлөлийн дарга, гишүүдийн үүрэг, эрх

5.1. Хамтарсан зөвлөлийн ерөнхий үйл ажиллагааг зөвлөлийн дарга удирдан зохион байгуулах бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1. Хамтарсан зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоох, хуралдааныг товлох, даргалах;

5.1.2. Хамтарсан зөвлөлийн гадаад, дотоод харилцааг зохицуулан төлөөлөх;

5.1.3. Хамтарсан зөвлөлийн техникийн ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоох, үйл ажиллагаанд хяналт тавих;

5.1.4. Хамтарсан зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

5.1.5. Хамтарсан зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар техникийн ажлын хэсгийн даргад үүрэг даалгавар өгч гүйцэтгэлд нь хяналт тавих;

5.1.6. Хамтарсан зөвлөлөөс бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтарч ажиллах асуудлыг шийдвэрлэх;

5.1.7. Хамтарсан зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг батлуулан зориулалтын дагуу захиран зарцуулах.

5.2. Хамтарсан зөвлөлийн гишүүн нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

5.2.1. Хамтарсан зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар техникийн ажлын хэсгийн даргад үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлд нь хяналт тавих;

5.2.2. Хамтарсан зөвлөлийн хурлаар асуудал хэлэлцүүлэхээр санал оруулах;

5.2.3. Хамтарсан зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэмэлт баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах.

Зургаа.Техникийн ажлын хэсгийн гишүүдийн үүрэг, эрх

6.1. Техникийн ажлын хэсгийн гишүүд нь салбар хоорондын хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг тухайн салбартаа зохион байгуулж, ажлын уялдааг хангах чиглэл барьж ажиллах;

6.2. Хамтарсан зөвлөлийн дарга, гишүүдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллах;

6.3. Хамтарсан зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

6.4. Хамтарсан зөвлөлийн шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд мэдээлэх;

6.5. Техникийн ажлын хэсгийн гишүүд нь салбар хоорондын хүрээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, тушаал зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохицуулах.

Долоо. Бусад

7.1. Хамтарсан зөвлөл нь ажлаа бүтэн жилээр төлөвлөнө.

7.2. Хамтарсан зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулж ЭМЯ, ХХААХҮЯ-нд хүргүүлнэ.

7.3. Хамтарсан зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэндийн болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний багцад тусган улсын төсвөөс болон Олон улсын байгууллагын дэмжлэгээр санхүүжүүлнэ.

Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

Зооноз өвчнөөс нийгмийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан зөвлөлийн бүрэлдэхүүн

- Дарга: Эрүүл мэндийн дэд сайд
- Орлогч дарга: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд
- Нарийн бичгийн дарга: Мал эмнэлгийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга, МУ-ын малын ерөнхий эмч
- Гишүүд:
- ЭМЯ-ны бодлого төлөвлөлтийн газрын дарга
 - ХХААХҮЯ-ны бодлого төлөвлөлтийн газрын дарга
 - Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал
 - Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал
 - Зоонозын өвчин судлалын үндэсний өтвийн захирал
 - Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал
 - ХӨСҮТ-ийн Монголын Талбарын Тархвар Судлал Сургалтын захирал
 - ОБЕГ-ын гамшгаас хамгаалах газрын дарга
 - МХЕГ-ын ХХААҮҮХГ-ын дарга (зөвшилцсөнөөр)
 - ДЭМБ-ын Халдварт өвчний хяналт, хариу арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
 - НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгч (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2018 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ...
дугаар хамтарсан тушаалын гуравдугаар хавсралт

**Зооноз өвчнөөс нийгмийн эрүүл мэндийг хамгаалах
хамтарсан зөвлөлийн техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Дарга: ЗГХА-МЭҮГ-ын дэд дарга, малын ерөнхий эмч

Нарийн бичгийн дарга: ЗӨСҮТ-ийн захирал

Гишүүд:

- ЭМЯ-ны хүнс болон орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМЯ-ны НЭМХ-ийн халдварт өвчний хяналт, урьдчилсан сэргийлэлтийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- ЗГХА-МЭҮГ-ын Ерөнхий эпидемиологич
- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дэд захирал, ерөнхий эмч
- МЭХ-ийн халдварт өвчин, дархлаа судлалын лабораторийн эрхлэгч
- МЭХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
- ЗӨСҮТ-ийн тархвар судлалын албаны дарга
- ЗӨСҮТ-ийн Нэгдсэн лабораторийн албаны дарга
- ХӨСҮТ-ийн зооноз, бруцеллёзын тасгийн эрхлэгч
- Монголын талбарын тархвар судлал сургалт хариуцсан мэргэжилтэн
- НЭМҮТ-ийн орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
- ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах газрын хүний гоц халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах газрын мал, амьтны гоц халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- МХЕГ-ын Үндэсний лавлагаа лабораторийн дарга (зөвшилцсөнөөр)
- МХЕГ-ын мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)
- МХЕГ-ын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)
- УЦУОШ Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)